



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/221

Булган сум

Ой, ойн санд аж ахуйн үйл ажиллагаа  
явуулахыг түр хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.18, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Засгийн газрын 2013 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам” 106 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” А/184 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссын 2024 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврын дагуу түймрийн аюултай үед ой, ойн сан бүхий газарт аялах, ан агнах, Бугын эвэр түүх, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл тус тус хориглосугай.

2. Дээрх хугацаанд түймрийн аюулын зэрэглэл, I-II зэрэглэлд хүрч буурсан үед иргэн, хуулийн этгээдүүд ой, хээрийн гал түймрээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, мод бэлтгэл, ойн арчилгаа, цэвэрлэгээний үед түймрийн аюулгүй байдлыг хангахад тавигдах тусгай шаардлагыг хангаж, орон нутгийн Засаг даргатай гал гаргахгүй байх гэрээ байгуулан, Онцгой байдлын газрын Гал түймрийн Улсын хяналтын байцаагчаар дүгнэлт гаргуулан, ой, ойн сангаас мод бэлтгэх үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

3. Түймрийн аюултай үед сум орон нутагтаа байнгын жижүүр ажиллуулж, аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тогтмол мэдээлж ажиллахыг сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Түймрийн аюулын ангилал, зэрэглэлийг өдөр бүр гаргаж, Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, сумын Засаг даргын Тамгын газарт мэдээлж ажиллахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (С.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ш.Баасандорж), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр), сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010309